



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

# **ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН МЭДЭЭ**

**2026 оны 01 дүгээр сар**

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ, СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 оны 02 сарын 26  
Улаанбаатар хот

# НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

## Үзүүлэлт

## Тодорхойлолт\*

Тээсэн ачаа	Тодорхой хугацаанд, тодорхой зайд тээвэрлэсэн нийт ачааг илэрхийлнэ. Тээсэн ачаа нь дотроо олон төрлийн байдгаас салбаруудын онцлогоос шалтгаалан ачааг шинж чанараар нь тодорхой бүлэг, ангилалд хуваадаг. Тээсэн бүх төрлийн ачааг тус бүр хэмжих нэгжийг нь харгалзахгүйгээр тонноор илэрхийлнэ.
Ачаа эргэлт	Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тн.км-ээр илэрхийлнэ.
Тээсэн зорчигч	Тодорхой хугацаанд тодорхой зайд тээвэрлэсэн нийт зорчигчдын тоог хэлнэ.
Зорчигч эргэлт	Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
Шилжүүлсэн тн.км	Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километр шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
Тээврийн орлого	Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэр тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд буюу ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм. Үүнийг тухайн оны үнээр тооцно.

\*Тээврийн салбарт ашиглагддаг ойлголт, тодорхойлолт

## ХЯНАСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БАЯНЗУЛ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ,  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.ГЭРЭЛНЯМ

## БОЛОВСРУУЛСАН:

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СТАНДАРТ,  
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ц.НЭМЭХЖАРГАЛ

Энэхүү эмхэтгэлийг ҮСХ, яам, харьяа байгууллагуудын болон Зам, тээврийн салбарын мэдээллийн нэгдсэн платформ<sup>1</sup> бүртгэгдэж буй тоон үзүүлэлт, статистик мэдээллийг нэгтгэн гаргалаа.

<sup>1</sup> Зам, тээврийн салбарын статистик мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, салбар байгууллагуудын мэдээлэл солилцооны уялдаа холбоог бэхжүүлэх, мэдээллийг түргэн шуурхай олон нийтэд хүргэх зорилгоор платформ 2022 оны 1 дүгээр сараас хөгжүүлж эхэлсэн.

## АГУУЛГА

<b>БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ .....</b>	<b>5</b>
1.1. АЧАА ТЭЭВЭР.....	6
1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР .....	7
<b>БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР.....</b>	<b>8</b>
2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА .....	8
2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....	8
<b>БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР .....</b>	<b>9</b>
3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА .....	9
3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ .....	13
<b>БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР .....</b>	<b>14</b>
4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА .....	14
4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ .....	14
4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ .....	16
4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ .....	17
4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ.....	18

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Зам, тээврийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт.....	5
Хүснэгт 2. Автотээврийн ачаа тээвэр.....	8
Хүснэгт 3. Автотээврийн зорчигч.....	8
Хүснэгт 4. Төмөр замын ачаа тээвэр.....	9
Хүснэгт 5. Төмөр замын зорчигч тээвэр.....	12
Хүснэгт 6. Агаарын тээврийн ачаа.....	13
Хүснэгт 7. Агаарын тээврийн зорчигч.....	14
Хүснэгт 8. Агаарын тээврийн олон улсын зорчигч.....	15
Хүснэгт 9. Агаарын тээврийн орон нутгийн зорчигч.....	16
Хүснэгт 10. Нислэг гүйцэтгэл.....	17

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Нийт ачаа тээвэр.....	6
Зураг 2. Нийт экспорт.....	6
Зураг 3. Нийт импорт.....	6
Зураг 4. Нийт зорчигч тээвэр.....	7
Зураг 5. Олон улсад зорчигч.....	7
Зураг 6. Орон нутгийн зорчигч.....	7
Зураг 7. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь.....	8
Зураг 8. Автотээврийн зорчигч.....	8
Зураг 9.Төмөр замын ачаа .....	9
Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	10
Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл.....	10
Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь.....	10
Зураг 13. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар.....	10
Зураг 14. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2025.07.31.....	11
Зураг 15. Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор.....	11
Зураг 16. Төмөр замын зорчигч тээвэр.....	12
Зураг 17. Төмөр замын зорчигч, хоногоор.....	12
Зураг 18. Агаараар тээвэрлэсэн ачаа болон шуудан.....	13
Зураг 19. Олон улс, орон нутгийн ачаа, шуудан.....	13
Зураг 20. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар.....	13
Зураг 21. Агаарын тээврээр зорчсон зорчигчдын тоо.....	14
Зураг 22. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар.....	14
Зураг 23. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр.....	15
Зураг 24. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар.....	16
Зураг 25. Орон нутгийн зорчигч, чиглэлээр.....	16
Зураг 26. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь.....	17
Зураг 27. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар.....	17

Зам, тээврийн салбарын статистикийн мэдээлэл – 2026 оны 01 дүгээр сар

БҮЛЭГ 1. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН СТАТИСТИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ<sup>2</sup>

Хүснэгт 1


№	Үзүүлэлт	Тээврийн төрөл	Хэмжих нэгж	2024 оны 01-р сар	2025 оны 01-р сар	2026 оны 01-р сар	Өсөлт бууралтын % 2026/2025
1	Тээвэрлэсэн ачаа	Автотээвэр	мян.тн	7,054.8	6,043.7	10,486.8	73.5%
		Төмөр зам	мян.тн	3,603.4	3,743.5	5,296.3	41.5%
		Агаар	мян.тн	0.8	0.6	0.7	8.9%
		<b>Нийт ачаа</b>	<b>мян.тн</b>	<b>10,659.0</b>	<b>9,787.8</b>	<b>15,783.8</b>	<b>61.3%</b>
2	Дамжин өнгөрөх ачаа /транзит/	Төмөр зам	мян.тн	433.3	399.0	446.7	11.9%
3	Ачаа гаргалт /экспорт/	Төмөр зам	мян.тн	902.0	1,031.1	1,078.5	4.6%
		Автотээвэр	мян.тн	6,845.1	5,815.5	10,263.1	76.5%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>7,747.1</b>	<b>6,846.5</b>	<b>11,341.6</b>	<b>65.7%</b>
4	Ачаа оруулалт /импорт/	Төмөр зам	мян.тн	357.4	345.6	419.5	21.4%
		Автотээвэр	мян.тн	209.7	228.2	223.8	-2.0%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>567.1</b>	<b>573.9</b>	<b>643.3</b>	<b>12.1%</b>
5	Дотоодод тээвэрлэсэн ачаа	Төмөр зам	мян.тн	1,910.8	1,967.7	3,351.6	70.3%
		Агаар	мян.тн	0.8	0.6	0.7	8.9%
		<b>Нийт</b>	<b>мян.тн</b>	<b>1,911.5</b>	<b>1,968.3</b>	<b>3,352.3</b>	<b>70.3%</b>
6	Ачаа эргэлт	Автотээвэр	сая тн.км	1,131.7	947.5	1,434.9	51.4%
		Төмөр зам	сая тн.км	1,746.8	1,768.1	2,200.4	24.4%
		Агаар	сая тн.км	2.1	1.8	2.3	30.1%
		<b>Нийт</b>	<b>сая тн.км</b>	<b>2,880.6</b>	<b>2,717.4</b>	<b>3,637.5</b>	<b>33.9%</b>
7	Зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	11,203.7	10,971.9	14,919.8	36.0%
		Төмөр зам	мян.хүн	165.0	157.7	150.6	-4.5%
		Агаар	мян.хүн	158.1	190.3	197.0	3.5%
		<b>Нийт зорчигч</b>	<b>мян.хүн</b>	<b>11,526.7</b>	<b>11,319.9</b>	<b>15,267.4</b>	<b>34.9%</b>
8	Олон улсад зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	75.9	54.0	30.0	-44.5%
		Төмөр зам	мян.хүн	2.2	3.3	3.3	-0.6%
		Агаар	мян.хүн	124.5	157.3	178.2	13.3%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>202.6</b>	<b>214.7</b>	<b>211.5</b>	<b>-1.5%</b>
9	Орон нутагт зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	139.0	148.8	150.2	0.9%
		Төмөр зам	мян.хүн	162.9	154.4	147.3	-4.6%
		Агаар	мян.хүн	33.5	32.9	18.8	-43.1%
		<b>Нийт</b>	<b>мян.хүн</b>	<b>335.4</b>	<b>336.1</b>	<b>316.3</b>	<b>-5.9%</b>
10	Нийслэл дэх нийтийн тээврийн зорчигчдын тоо	Автотээвэр	мян.хүн	10,988.8	10,769.0	14,739.6	36.9%
11	Зорчигч эргэлт	Автотээвэр	сая хүн.км	184.7	189.5	156.0	-17.7%
		Төмөр зам	сая хүн.км	68.2	67.5	68.4	1.3%
		Агаар	сая хүн.км	406.9	554.9	597.0	7.6%
		<b>Нийт</b>	<b>сая хүн.км</b>	<b>659.8</b>	<b>811.9</b>	<b>821.4</b>	<b>1.2%</b>
12	Агаарын тээврийн нислэгийн тоо	Олон улсын хөөрөлт, буултын тоо	ш	885.0	1,115.0	1,326.0	18.9%
		Орон нутгийн хөөрөлт, буултын тоо	ш	626.0	628.0	669.0	6.5%
		Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо	ш	5,020.0	6,410.0	7,306.0	14.0%

<sup>2</sup> Зам, тээврийн салбарын 2026 оны 1 дүгээр сарын статистикийн мэдээг 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдөр гаргав.

1.1. АЧАА ТЭЭВЭР


Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2026 оны 1 дүгээр сард 15.8 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61.3%-аар өссөн бол өмнөх сартай харьцуулахад 5.7%-аар буурсан үзүүлэлттэй байна.

- Автотээврээр 2026 оны 1 дүгээр сард 10.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 1 дүгээр сартай харьцуулахад 74%-аар өссөн бол өмнөх сар буюу 12 дугаар сартай харьцуулахад 5.8%-аар буурсан байна. Үүнээс экспортод 10.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 76%-аар өссөн бол импортоор 223.8 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 1 дүгээр сараас 2%-аар өссөн үзүүлэлттэй байна.
- Төмөр замын тээврээр 2026 оны 1 дүгээр сард нийт 5.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.5%-аар өссөн бол өмнөх сартай харьцуулахад 5.7%-ийн бууралттай гарсан байна. Үүнээс дотоодын ачаа 3.4 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 70.3%-аар, дамжин өнгөрсөн ачаа 446.7 мянган тонн болж 11.9%-аар, импортын ачаа 419.5 мянган тонн болж 21.4%-аар, экспортын ачаа 1.1 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 4.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Агаарын тээврээр 2026 оны 1 дүгээр сард 683.1 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.9%-аар өссөн бол өмнөх сартай харьцуулахад 45.1%-аар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс ачаа 669.1 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.8%-аар өссөн бол шуудан 13.9 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21.6%-аар буурсан байна.



Экспортоор 2026 оны 1 сард 11.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 76.5%-аар өссөн байна. Үүнээс төмөр замаар 1.1 сая тонн тээвэрлэсэн нь 4.6%-аар, автотээврээр 10.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 76.5%-аар тус тус өссөн байна. Нийт экспортын дүнд автотээвэр 90%-ийг, төмөр зам 10%-ийг эзэлж байна. /Зураг 2/

Импортын ачаа 2026 оны 1 сард нийт 643.3 мянган тонн болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.1%-аар өссөн. Үүнээс төмөр замаар 419.5 мянган тонн ачаа импортолсон нь 21.4%-аар өссөн бол автотээврээр 223.8 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0%-аар буурсан байна. Импортын тээврийн 65%-ийг төмөр замаар, 35%-ийг автотээврээр тээсэн байна. /Зураг 3/




1.2. ЗОРЧИГЧ ТЭЭВЭР

Бүх төрлийн тээврээр 2026 оны 1 дүгээр сард 15.3 сая зорчигч (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.9%-аар өсжээ.

- Автотээврээр 2026 оны 1 дүгээр сард 14.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36%-аар өссөн байна. Үүнээс орон нутагт 150.2 мянган зорчигч (+0.9%), олон улсад 29.9 мянган зорчигч (-44.5%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 14.7 сая зорчигч (+36.9%) тус тус зорчсон байна. /Доорх графикт нийслэлийн нийтийн тээврийн зорчигчийг хассан болно./
- Төмөр замын тээврээр 2026 оны 1 дүгээр сард нийт 150.6 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5%-аар буурсан. Үүнээс олон улсад 3.3 мянган зорчигч зорчсон нь 0.6%-аар, орон нутагт 147.3 мянган зорчигч зорчсон нь 4.6%-аар тус тус буурчээ.
- Агаарын тээврээр 2026 оны 1 дүгээр сард агаарын тээврээр нийт 197 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5%-аар, өмнөх сартай харьцуулахад 8.4%-аар тус тус өссөн байна. Үүнээс олон улсад 178.2 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 13.3%-аар өссөн бол орон нутагт 18.8 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 43.1%-аар буурсан үзүүлэлттэй байна


Зураг 4. Нийт зорчигч тээвэр, мян. хүн



Олон улсад нийт 211.5 мянган зорчигч (-1.5%) зорчсон бөгөөд үүнээс агаарын тээврээр 178.2 сая зорчигч (+13.3%), автотээврээр 30.0 мянган зорчигч (-44.5%), төмөр замаар 3.3 мянган зорчигч (-0.6%) тус тус зорчсон байна. Олон улсад зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 75%, автотээвэр 23%, төмөр зам 2%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 5/

Орон нутагт нийт 316.3 мянган зорчигч (-5.9%) зорчсон бөгөөд үүнээс автотээврээр 150.2 мянган зорчигч (+0.9%), төмөр замаар 147.3 мянган зорчигч (-4.6%), агаарын тээврээр 18.8 мянган зорчигч (-43.1%) тус тус зорчоод байна. Орон нутагт зорчигчдын нийт дүнд агаарын тээвэр 6%, автотээвэр 47%, төмөр зам 47%-ийг тус тус эзэлж байна. /Зураг 6/

Зураг 6. Орон нутгийн зорчигч



**БҮЛЭГ 2. АВТОТЭЭВРИЙН САЛБАР**

**2.1. АВТОТЭЭВРИЙН АЧАА**

**2026 оны 1 дүгээр сард авто замаар 10.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 74%-аар өслөө.**


Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Хүснэгт 2
					Өсөлт бууралтын % 2026/2025
<b>Нийт ачаа</b>	<b>мян.тн</b>	<b>7,054,799.8</b>	<b>6,043,687.9</b>	<b>10,486,840.0</b>	<b>74%</b>
Импорт	мян.тн	6,845,097.4	5,815,459.8	10,263,069.7	76%
Экспорт	мян.тн	209,702.4	228,228.1	223,770.4	-2%
Ачаа эргэлт	сая тн.км	1,131.7	947.5	1,434.9	51%

2026 оны 1 дүгээр сард автотээвэрээр 10.5 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 74%-аар өссөн бол өмнөх сар буюу 12 дугаар сартай харьцуулахад 5.8%-аар буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс экспортод 10.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь 76%-аар өссөн бол импортоор 223.8 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны 1 дүгээр сараас 2%-аар өссөн үзүүлэлттэй байна. Харин ачаа эргэлт 1 дүгээр сард 1,434.9 сая тонн км болсон нь өмнөх оны 1 дүгээр сараас 51%-аар өссөн байна.

Ачаа тээврийн 98%-ийг экспортын ачаа, 2%-ийг импортын ачаа эзэлж байна. Экспортын ачаанд уул уурхайн бүтээгдэхүүний ачаа 99.8% эзэлж байгаа бол үүнээс нүүрс 96.7%-ийг эзэлж байна. /Зураг 7/

2026 оны 1 дүгээр сард 9.9 сая тонн нүүрс экспортод гарсан нь өмнөх оны мөн үеэс 78%-аар өссөн нь тээврийн хэмжээ өсөхөд голлон нөлөөлжээ.


**Зураг 7. Автотээврийн ачааны экспорт, импортын эзлэх хувь**



**2.2. АВТОТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ**

Зорчигч тээвэр	Хэмжих нэгж	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Хүснэгт 3
					Өсөлт бууралтын % 2026/2025
<b>Нийт зорчигч</b>	<b>хүн</b>	<b>11,203,658.0</b>	<b>10,971,889.0</b>	<b>14,919,808.0</b>	<b>36.0%</b>
Олон улсад	хүн	75,919.0	54,013.0	29,992.0	-44.5%
Орон нутагт	хүн	138,988.0	148,833.0	150,216.0	0.9%
Хот доторх нийтийн тээвэр	хүн	10,988,751.0	10,769,043.0	14,739,600.0	36.9%
Зорчигч эргэлт	сая хүн.км	184.7	189.5	156.0	-17.7%

Зураг 8. Зорчигч тээвэр



Автотээвэрээр 2026 оны 1 дүгээр сард 14.9 сая зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36%-аар өссөн байна. Үүнээс орон нутагт 150.2 мянган зорчигч (+0.9%), олон улсад 29.9 мянган зорчигч (-44.5%), нийслэлийн нийтийн тээврийн хэрэгслээр 14.7 сая зорчигч (+36.9%) тус тус зорчсон байна.

Автотээврийн зорчигчийн 98.7%-ийг нийслэлийн нийтийн тээвэр, 1.0%-ийг хот хооронд буюу орон нутгийн зорчигч, 0.3%-ийг олон улсын зорчигчид эзэлж байна. /Зураг 8/

### БҮЛЭГ 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАР

#### 3.1. ТӨМӨР ЗАМЫН АЧАА

Төмөр замын тээврээр 2026 оны 1 дүгээр сард 5.3 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.5%-аар өслөө.

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Хүснэгт 4
					Өсөлт бууралтын % 2026/2025
<b>Ачаа тээвэрлэлт</b>	<i>мян.тн</i>	<b>3,603.4</b>	<b>3,743.5</b>	<b>5,296.3</b>	<b>41.5%</b>
"Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	2,947.2	2,947.8	3,175.4	7.7%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	135.5	185.7	1,228.4	561.7%
"Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>	171.1	225.0	-	-100.0%
"Монголиантранс Ложистик" ХХК	<i>мян.тн</i>	312.5	308.7	300.4	-2.7%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>	37.2	76.4	592.1	675.5%
Дотоодын ачаа	<i>мян.тн</i>	1,910.8	1,967.7	3,351.6	70.3%
үүнээс "Улаанбаатар төмөр зам" ХНН	<i>мян.тн</i>	1,254.5	1,172.0	1,230.7	5.0%
"Монголын төмөр зам" ТӨХК	<i>мян.тн</i>	135.5	185.7	1,228.4	561.7%
"Тавантолгой төмөр зам" ХХК	<i>мян.тн</i>	171.1	225.0	-	-100.0%
"Монголиантранс Ложистик" ХХК	<i>мян.тн</i>	312.5	308.7	300.4	-2.7%
"Монголиантранс Лайн" ХХК	<i>мян.тн</i>	37.2	76.4	592.1	675.5%
Импорт ачаа	<i>мян.тн</i>	357.4	345.6	419.5	21.4%
БНХАУ-аас	<i>мян.тн</i>	107.5	71.9	144.9	101.5%
ОХУ-руу	<i>мян.тн</i>	249.9	273.7	274.6	0.3%
Экспорт ачаа	<i>мян.тн</i>	902.0	1,031.1	1,078.5	4.6%
БНХАУ-руу	<i>мян.тн</i>	894.9	1,017.3	1,069.9	5.2%
ОХУ-руу	<i>мян.тн</i>	7.2	13.8	8.6	-37.8%
Дамжин өнгөрөх ачаа	<i>мян.тн</i>	433.3	399.0	446.7	11.9%
БНХАУ-аас ОХУ-руу	<i>мян.тн</i>	117.6	120.4	159.9	32.8%
ОХУ-аас БНХАУ-руу	<i>мян.тн</i>	315.7	278.7	286.8	2.9%
Ачаа эргэлт	<i>сая.тн-км</i>	1,746.8	1,768.1	2,200.4	24.4%

Төмөр замын тээврээр 2026 оны 1 дүгээр сард нийт 5.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 41.5%-аар өссөн бол өмнөх сартай харьцуулахад 5.7%-ийн бууралттай гарсан байна. Үүнээс дотоодын ачаа 3.4 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 70.3%-аар, дамжин өнгөрсөн ачаа 446.7 мянган тонн болж 11.9%-аар, импортын ачаа 419.5 мянган тонн болж 21.4%-аар, экспортын ачаа 1.1 сая тонн болж өмнөх оны мөн үеэс 4.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Хүснэгт 4/

Зураг 9. Төмөр замын ачаа, мян.тн



Зураг 10. Төмөр замын ачаа, байгууллагуудын эзлэх хувь



Ачаа тээвэрлэлтийн төрлөөр авч үзвэл нийт ачаа тээврийн 3.4 сая тонн буюу 63%-ийг дотоодын ачаа, 1.1 сая тонн буюу 21%-ийг экспортын ачаа, 446.7 мянган тонн буюу 8%-ийг дамжин өнгөрсөн ачаа, 419.5 сая тонн буюу 8%-ийг импортын ачаа тээвэр эзэлж байна. /Зураг 11/

2026 оны 1 дүгээр сарын байдлаарх нийт ачаа тээврийн 3.2 сая тонн буюу 60%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 1.2 сая тонн буюу 23%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 592.1 мянган тонн буюу 11%-ийн ачааг "Монголиантранс Логистик" ХХК, 300.4 мянган тонн ачаа буюу нийт ачааны 6%-ийг "Монголиантранс Лайн" ХХК-иуд тус тус тээвэрлэсэн байна. /Зураг 10/

Зураг 11. Төмөр замын ачаа тээврийн төрөл




**Зураг 12. Дотоодын ачаа, байгууллагуудын эзлэх хувь**




Дотоодод тээвэрлэсэн 3.4 сая тонн ачааны 1.2 сая тонн ачаа буюу 37%-ийг "Улаанбаатар төмөр зам" ХНН, 1.2 сая тонн буюу 36%-ийг "Монголын төмөр зам" ТӨХК, 300.4 мянган тонн ачаа буюу 9%-ийг "Монголиантранс Ложистик" ХХК, 592.1 сая тонн буюу 18%-ийг "Монголиантранс Лайн" ХХК тус тус эзэлж байна. /Зураг 12/

2026 оны 1 дүгээр сарын байдлаар байгууллагуудын ачаа тээврийн хоногийн дундажийг тооцоход "УБТЗ" ХНН хоногт дунджаар 102.4 мянган тонн, "МТЗ" ТӨХК нь 39.6 мянган тонн, "МТЛожистик" ХХК нь 9.7 мянган тонн, "МТЛайн" ХХК нь 19.1 мянган тонн ачаа тээвэрлэж байна. /Зураг 13/

**Зураг 13. Хоногт тээвэрлэх ачааны дундаж жин, мян.тн, байгууллагаар**




Зураг 14. Төмөр замаар тээвэрлэсэн ачааны хэмжээ, өдрөөр, 2025.01.01-2026.01.31



Төмөр замын байгууллагуудаар өдөр бүр тээвэрлэсэн ачааны хэмжээг төрлөөр нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуос оруулав. 2026 оны 1 сарын байдлаар өдөрт дундажаар орон нутгийн ачаа 108.1 мянга, экспортын ачаа 34.8 мянга, дамжин өнгөрсөн ачаа 14.4 мянга, импортод дундажаар 13.5 мянган ачаа тээвэрлэсэн байна. /Зураг 14/

Зураг 15 . Төмөр замын байгууллагуудын ачаа тээвэр, хоногоор




2025.01.01-2026.01.31-ний өдрийг хүртэлх төмөр замын тээврийн байгууллагуудын тээвэрлэсэн ачааны хоног бүрийн мэдээг графикаар харуулав. /Зураг 15/

3.2. ТӨМӨР ЗАМЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 5

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Өсөлт бууралтын % 2026/2025
<b>Зорчигч тээвэрлэлт</b>	<i>мян.хүн</i>	<b>165.0</b>	<b>157.7</b>	<b>150.6</b>	<b>-4.5%</b>
Олон улс	<i>мян.хүн</i>	2.2	3.3	3.3	-0.6%
Орон нутаг	<i>мян.хүн</i>	162.9	154.4	147.3	-4.6%
Зорчигч эргэлт	<i>сая хүн.км</i>	68.2	67.5	68.4	1.3%

Зураг 16. Төмөр замын зорчигч тээвэр




2026 оны 1 дүгээр сард нийт 150.6 мянган зорчигч төмөр замаар зорчиж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.5%-аар буурсан. Үүнээс олон улсад 3.3 мянган зорчигч зорчсон нь 0.6%-аар, орон нутагт 147.3 мянган зорчигч зорчсон нь 4.6%-аар тус тус буурчээ.

Зорчигч эргэлт 68.4 сая хүн км болсон нь өмнөх оны мөн үеэс 1.3%-аар өсжээ.

Зорчигч тээвэрлэлт буурсан гол шалтгаан нь төмөр замын зорчигч тээврийн 98%-ийг эзэлж буй орон нутагт зорчих зорчигчдын тоо тогтмол буурч байгаатай холбоотой бөгөөд зорчигчид орон нутагт вагоноор зорчихоос илүү автомашинаар зорчих нь нэмэгдсэн байна. /Зураг 16/

Зураг 17. Төмөр замын зорчигч, хоногоор



2025.01.01-2026.01.31-ний өдрүүдэд Улаанбаатар төмөр замаар зорчсон зорчигчийн тоог хоногоор нь Зам, тээврийн салбарын нэгдсэн платформуус нэгтгэн гаргав. 2026 оны 1 сарын байдлаар төмөр замаар хоногт дундажаар 4.6 мянган зорчигч зорчиж байна. /Зураг 17/

**БҮЛЭГ 4. ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАР**

**4.1 АГААРЫН ТЭЭВРИЙН АЧАА**

Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Өсөлт бууралтын % 2026/2025
1	<b>Нийт ачаа, шуудан тээвэр</b>	тн	<b>762.3</b>	<b>627.3</b>	<b>683.1</b>	<b>8.9%</b>
2	олон улсад	тн	759.6	625.5	678.1	8.4%
3	орон нутагт	тн	2.65	1.8	5.0	180.0%
4	<b>Нийт ачаа</b>	тн	<b>742.8</b>	<b>609.6</b>	<b>669.2</b>	<b>9.8%</b>
5	олон улсад	тн	740.1	607.8	664.2	9.3%
6	орон нутагт	тн	2.64	1.8	5.0	180.0%
7	<b>Нийт шуудан</b>	тн	<b>19.54</b>	<b>17.7</b>	<b>13.9</b>	<b>-21.6%</b>
8	олон улсад	тн	19.53	17.7	13.9	-21.6%
9	орон нутагт	тн	0.01	0.0	0.0	-
10	<b>Ачаа, шуудан эргэлт</b>	мян.тн-км	<b>2,064.0</b>	<b>1,763.8</b>	<b>2,294.4</b>	<b>30.1%</b>
11	олон улсад	мян.тн-км	2,062.6	1,762.8	2,291.5	30.0%
12	орон нутагт	мян.тн-км	1.4	1.0	2.9	202.1%



Агаарын тээврээр 2026 оны 1 дүгээр сард 683.1 тонн ачаа, шуудан тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.9%-аар өссөн бол өмнөх сартай харьцуулахад 45.1%-аар буурсан үзүүлэлттэй байна.

Үүнээс ачаа 669.1 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 9.8%-аар өссөн бол шуудан 13.9 тонн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 21.6%-аар буурсан байна. /Зураг 18/

Олон улсад тээвэрлэсэн ачаа шуудан 678.1 тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 8.4%-аар, орон нутагт тээвэрлэсэн ачаа шуудан 5 тонн болж өмнөх оны мөн үеэс 3 дахин тус тус өссөн байна. /Зураг 19/

Агаарын тээврээр тээвэрлэсэн нийт ачаа шуудангийн 99.3%-ийг олон улсад тээвэрлэсэн бол 0.7%-ийг орон нутагт тээвэрлэсэн байна. Мөн нийт ачаа шуудангийн 98%-ийг ачаа эзэлж байгаа бол 2%-ийг шуудан эзэлж байна.

Ачаа эргэлт 2026 оны 1 дүгээр сард 2.9 сая тонн км болсон нь өмнөх оны мөн үеэс 30.1%-аар өсжээ.



**Зураг 20. Нийт ачаа, шуудан тээвэр, тонн, сараар**




4.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ЗОРЧИГЧ

Агаарын тээврээр 2026 оны 1 дүгээр сард нийт 197 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 3.5%-аар өслөө.

Хүснэгт 7

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Өсөлт бууралтын % 2026/2025
<b>Нийт зорчигч</b>	<b>хүн</b>	<b>158,078</b>	<b>190,264</b>	<b>196,989</b>	<b>3.5%</b>
Олон улсад	хүн	124,530	157,332	178,237	13.3%
Орон нутагт	хүн	33,548	32,932	18,752	-43.1%
<b>Зорчигч эргэлт</b>	<b>мян.хүн км</b>	<b>406,886.2</b>	<b>554,921.1</b>	<b>597,038</b>	<b>7.6%</b>
Олон улсад	мян.хүн км	387,174.3	535,631.5	578,286	8.0%
Орон нутагт	мян.хүн км	19,711.9	19,289.6	18,753	-2.8%



2026 оны 1 дүгээр сард агаарын тээврээр нийт 197 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5%-аар, өмнөх сартай харьцуулахад 8.4%-аар тус тус өссөн байна. Үүнээс олон улсад 178.2 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 13.3%-аар өссөн бол орон нутагт 18.8 мянган зорчигч зорчиж өмнөх оны мөн үеэс 43.1%-аар буурсан үзүүлэлттэй байна. /Хүснэгт 7/

Сар бүрийн зорчигч тээврийн үзүүлэлтийг харахад 6 дугаар сараас 9 дүгээр сар хүртэл ачаалал нэмэгдсэн нь зуны улиралд аялал жуулчлалын зорилгоор зорчих иргэдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна./Зураг 22/

**Зураг 22. Агаарын тээврийн зорчигчдын тоо, сараар**




Зорчигч эргэлт 2026 оны 1 дүгээр сард 597 сая хүн км болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.6%-аар өссөн. Үүнээс олон улсын зорчигч эргэлт 578.3 сая хүн км болж 8.0%-аар өссөн бол орон нутгийн зорчигч эргэлт 18.8 сая хүн км болж 2.8%-аар буурсан байна.

4.2.1. АГААРЫН ТЭЭВРИЙН ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧ

Хүснэгт 8

№	Үзүүлэлт	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Өсөлт бууралтын % 2026/2025
1	<b>Олон улсад</b>	<b>124,530</b>	<b>157,332</b>	<b>178,237</b>	<b>13.3%</b>
2	чиглэл Сөүл	36,226	41,515	46,129	11.1%
3	Бээжин	20,613	23,186	26,575	14.6%
4	Фукуок	10,350	12,411	13,056	5.2%
5	Токио	7,941	10,522	12,352	17.4%
6	Истанбул	9,349	10,753	9,574	-11.0%
7	ХонКонг	7,588	9,408	9,243	-1.8%
8	Хөх хот	3,511	5,548	9,005	62.3%
9	Санья/Хайнань	1,918	4,518	7,552	67.2%
10	Бангкок	5,146	6,503	6,071	-6.6%
11	Франкфурт	4,750	5,212	5,518	5.9%
12	Эрээн	-	-	4,804	-
13	Пукет	4,783	5,534	4,681	-15.4%
14	Ордос	-	1,317	4,356	230.8%
15	Сингапур	-	-	4,200	-
16	Хо Ши Мин	1,695	4,915	3,736	-24.0%
17	На Транг	334	2,966	2,847	-4.0%
18	Хайлаар/Хөлөнбуйр	1,726	-	1,694	-
19	Алмата	1,064	1,704	1,599	-6.2%
20	Шанхай	-	-	1,381	-
21	Ханой	983	1,138	1,214	6.7%
22	Бусад чиглэлд	6,553	10,182	2,650	-74.0%

Зураг 23. Олон улсын зорчигч тээвэр, чиглэлээр



2026 оны 1 дүгээр сарын байдлаар олон улсад нийт 178.2 мянган зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеэс 13.3%-аар өссөн. Хамгийн их зорчигч зорчсон Сөүл чиглэлд 46.1 мянган зорчигч (+11.1%), Бээжин хотруу 26.6 мянган зорчигч (+14.6%), Фукуок чиглэлд 13.1 мянган зорчигч (+5.2%), Токио чиглэлд 12.4 мянган зорчигч (+17.4%), Истанбул чиглэлд 9.6 мянган зорчигч (-11%), ХонгКонг чиглэлрүү 9.2 мянган зорчигч (-1.8%), Хөх хот чиглэлд 9.0 мянган зорчигч (+62.3%), Санья чиглэлд 7.6 мянган зорчигч (+67.2%), Бангкок чиглэлд 6.1 мянган зорчигч (-6.6%) тус тус тээвэрлэсэн байна. Ордос, Хөх хот, Санья/Хайнань, Эрээн чиглэлд зорчигчийн тоо эрс нэмэгдсээр байна. Дээрх графикт 2026 онд хамгийн их зорчигч зорчсон 20 хотуудыг харуулав. /Зураг 23/

Зураг 24. Олон улсын зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудаар



Олон улсад зорчсон зорчигчдын 44% буюу 78.4 мянган зорчигч үндэсний агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК нислэгээр ниссэн бол “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр 28 мянга, “Айрчайна”-ийн нислэгээр 18.6 мянга, “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр 16.7 мянга, “Корейн айр”-ийн нислэгээр 12.5 мянга, Туркиш айр нислэгээр 6.3 мянга, Жэжү айр нислэгээр 4.6 мянга, Ашиана эйрлайнс нислэгээр 4.1 мянга, Чайна юнайтед эйрлайнс нислэгээр 4.1 мянга, Жуньёо айр нислэгээр 2.9 мянга, Вьетжет айр нислэгээр 1.8 мянга, Ираеро нислэгээр 0.9 мянган зорчигч, Красавиа нислэгээр 12.7 мянга, захиалгат нислэгээр 11 зорчигч тус тус олон улсад зорчсон байна. /Зураг 24/

#### 4.2.2. АГААРЫН ТЭЭВРИЙН ОРОН НУТГИЙН ЗОРЧИГЧ

Хүснэгт 9

№	Үзүүлэлт	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Өсөлт бууралтын % 2026/2025
1	<b>Орон нутагт зорчигч тээвэр</b>	<b>33,548</b>	<b>32,932</b>	<b>18,752</b>	<b>-43.1%</b>
2	чиглэл Оюутолгой	29,608	28,451	13,888	-51.2%
3	Ховд	846	1,141	1,381	21.0%
4	Өлгий	601	1,161	1,334	14.9%
5	Улаангом	120	499	607	21.6%
6	Улиастай	470	553	440	-20.4%
7	Мөрөн	103	539	389	-27.8%
8	Алтай	567	588	367	-37.6%
9	Баянхонгор	-	-	346	-51.2%
10	Бусад чиглэлд	1,233	-	-	-


Зураг 25. Орон нутгийн зорчигч, чиглэлээр



2026 оны 1 дүгээр сард орон нутагт нийт 18.9 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 43.1%-аар, өмнөх сартай харьцуулахад 46.4%-аар тус тус буурсан байна.

Оюутолгой чиглэлийн зорчигчийн тоо 13.9 мянга болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51.2%-аар буурсан нь орон нутгийн зорчигч бууралтад голлон нөлөөлжээ. /Хүснэгт 9/

**Зураг 26. Орон нутгийн зорчигч, агаарын тээвэрлэгч байгууллагуудын эзлэх хувь**



Орон нутагт зорчигчдын 62% буюу 19.8 мянган зорчигч “МИАТ” ТӨХК-ийн нислэгээр, 26% буюу 8.4 мянган зорчигч “Аэро Монголиа” ХХК-ийн нислэгээр, 12% буюу 3.7 мянган зорчигч “Хүннү Эйр” ХХК-ийн нислэгээр тус тус зорчсон байна. Орон нутагт “МИАТ” ХХК-ийн зорчигч 9.3%-аар буурсан бол “Аэро Монголиа” ХХК зорчигч 8.6%-аар, “Хүннү эйр” ХХК-аар зорчсон зорчигчийн тоо 8.7%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. /Зураг 26/

### 4.3. НИСЛЭГ ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 10

Үзүүлэлт	2024.01 сар	2025.01 сар	2026.01 сар	Өсөлт бууралтын % 2026/2025
<b>Нийт нислэгийн тоо</b>	6,531	8,153	9,301	14.1%
Олон улсын өнгөрөлтийн нислэг	5,020	6,410	7,306	14.0%
Хөөрөлт, буулт	1,511	1,743	1,995	14.5%
Олон улсын хөөрөлт, буулт	885	1,115	1,326	18.9%
Орон нутгийн хөөрөлт, буулт	626	628	669	6.5%

2026 оны 1 сард нийт нислэгийн тоо 9.3 мянга болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.1%-аар, үүнээс олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо 7.3 мянга болж 14%-аар тус тус өссөн байна. Олон улсын хөөрөлт, буулт 1.3 мянга болж 18.9%-аар, орон нутгийн хөөрөлт, буултын тоо 669 болж 6.5%-аар тус тус өссөн байна. /Зураг 27/

**Зураг 27. Нислэг гүйцэтгэлийн мэдээ, сараар**

